

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ  
ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ХАМААРАХ  
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН  
ТАНИЛЦУУЛГА

/2021 оны эхний хагас жилийн байдлаар/

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24, Засгийн газрын 2020 оны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 203 дугаар тогтоолд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

**ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНДЭСЛЭЛ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.**

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов. Ингэхдээ Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2021 оны эхний хагас жилийн тайланг судлах, Монгол Улсын болон барааны экспорт, импортын статистикийн 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн урьдчилсан мэдээлэлтэй тулгаж шалгах, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж ярилцах, тодруулга авах арга хэлбэрээр хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо. Үүнд: “үр дүнтэй” – 100.0%, “тодорхой үр дүнд хүрсэн” – 70.0 - 99.0%, “эрчимжүүлэх шаардлагатай” – 31.0 - 69.0%, “үр дүнгүй” – 0 - 30.0% үнэлгээг гаргалаа.

**ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах 4 зорилтын 57 арга хэмжээнээс 2021 онд хэрэгжүүлэхээр тодорхойлсон хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд үндэслэн 44 арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд тусгагдсанаар жилд хоёр удаа гаргахаар заасан 4 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 2021 оны эхний хагас жилийн байдлаар 50.0 хувьтай байна. (Хүснэгт 1)

Нийт 44 арга хэмжээний 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 64.4 хувьтай байна. (Хүснэгт 2)

## ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

Хүснэгт 1

№	Зорилтын нэр	Шалгуур үзүүлэлтийн тоо		Үнэлгээ	
3.3	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ	15		50.0	
№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх/хүрсэн түвшин -2021 он	Үнэлгээ
1	Хүнсний ногооны хангамж	хувь	40	55/жилд 1 удаа	-
2	Төмсний хангамж	хувь	100	100/жилд 1 удаа	-
3	Буудайн хангамж	хувь	100	100/жилд 1 удаа	-
4	Махны нөөц бүрдүүлсэн хэмжээ	мян.тонн	11	20/жилд 1 удаа	-
5	Мах, махан бүтээгдэхүүний экспортын хэмжээ	мян.тонн	59	70/21.4	0
6	Сэрүүний улиралд нийлүүлсэн сүү	сая.литр	17	20/8.6	0
7	Тослог ургамлын дотоодын хангамж, дотоодын үйлдвэрийн хэрэгцээний хангалт	мян.тонн	0	48/жилд 1 удаа	
		хувь	0	50/жилд 1 удаа	
8	Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ	тоо	131	5/8	100
9	Отрын тусгай хэрэгцээний нөөц нутаг	сая.га	3.0	3.3/3.4	100
10	Малчин өрхийн дундаж орлогын өсөлт	хувь	1180662 төг	10%/жилд 1 удаа	-
11	Мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан малчин өрх	хувь	0	83.5/жилд 1 удаа	-
12	Мал, амьтны зоонозын халдварт өвчний голомт, тохиолдлын бууралт	хувь	Бруцеллёзын халдварлалтын түвшин 0,26%	0.02/жилд 1 удаа	-
		хувь	Галзуугийн 216 голомтод, 284 тохиолдол	1.0/жилд 1 удаа	-
		хувь	Боомын 6 голомтод, 44 тохиолдол	1.0/жилд 1 удаал	-

Зорилтын шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийг жилд хоёр удаа тайлагнах бол 11 шалгуур үзүүлэлтийг жилд нэг удаа тайлагнахаар төлөвлөсөн байна.

## АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 2

Үнэлгээ	Арга хэмжээ	
	Тоо	Эзлэх хувь
100	7	15.9
90	5	11.4
70	12	27.3
50	12	27.3
30	7	15.9
0	-	-
ХБгүй	13	-
Дүн	57	100.0

Жич: Эзлэх хувийг хэрэгжүүлсэн нийт 44 арга хэмжээний үнэлгээнээс тооцсон.

## Тодорхойлсон бодлого тус бүрийн хэрэгжилтийн үнэлгээ

Хүснэгт 3

№	Бодлогын нэр	Арга хэмжээний тоо	Дундаж үнэлгээ
1	Ковид – 19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	1	70.0%
2	Эдийн засгийн бодлого	41	63.0%
3	Засаглалын бодлого	1	90.0%
4	Ногоон хөгжлийн бодлого	1	90.0%

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ.

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны стратеги төлөвлөгөө, нэгж, харьяа байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээг тусгаж өгсөн нь хэрэгжилтэд эерэг үр дүн үзүүлж байгаа боловч тайлагналтад ач холбогдол өгч, иж бүрэн, нотолгоотойгоор тайлагнаж ажиллах шаардлагатай байна.
- Тодорхой үр дүнд хүрсэн болон үр дүнтэй арга хэмжээ нийт арга хэмжээний 54.6% /24/-ийг, үр дүнгүй арга хэмжээ 15.9% /7/, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ 27.3% /12/-ийг тус тус эзэлж байна.
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр эрчимжүүлэх шаардлагатай /31.0-69.0%/ болон үр дүнгүй /0-30.0%/ гэж дүгнэгдсэн арга хэмжээнээс жилийн эцсийн тайлант хугацаанд хэрэгжилт хангагдах боломжтой буюу үргэлжлэн хэрэгжиж байгаа арга хэмжээ 8 байна.
- Удирдлага, зохион байгуулалт, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай 3 арга хэмжээ
  - 3.3.3.7 Тослог ургамлын хангамж нэмэгдүүлэх /Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/,
  - 3.1.20.1 Экспортын баталгааны сан бий болгох /Жижиг, дунд үйлдвэрийн газар/,
  - 3.3.6.2 Монгол малчин арга хэмжээ /Мал аж ахуйн хэрэгжилтийг зохицуулах газар/ арга хэмжээ,

5. Коронавируст халдвар (Covid-19)-т цар тахлын халдвараас шалтгаалж байгаа 2 арга хэмжээ
  - а. 3.3.8.1 Биокомбинат үйлдвэрийн шинэчлэл /Гадаад хамтын ажиллагааны хэлтэс, Мал эмнэлгийн ерөнхий газар/,
  - б. 3.3.3.2 Махны экспортыг нэмэгдүүлэх /Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/ арга хэмжээ,
6. Санхүү, хөрөнгө оруулалтаас шалтгаалж байгаа 6 арга хэмжээ
  - а. 3.3.4.7 Бог малыг шахан бордох төв байгуулах /Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/,
  - б. 3.3.9.2 Ноос ноолууран бүтээгдэхүүний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх /Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/,
  - с. 3.3.12.1 Мах, ногооны хадгалалт борлуулалтын цогцолбор байгуулах /Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/,
  - д. 3.3.4.4.1 Уст цэгийг тогтоох хайгуул хийх /Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/,
  - е. 3.7.1.7, 3.3.10.1 Дархан паркийн асуудал /Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/ арга хэмжээ тус тус байна.

#### ТАВ. ЗӨВЛӨМЖ.

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тайланг тайланд тавигдах шаардлагад нийцүүлэн үнэн бодитой, иж бүрэн, нотолгоотойгоор цаг хугацаанд нь тайлагнах, санхүүжилтийн талаарх мэдээлэл, арга хэмжээний хэрэгжээгүй шалтгааныг тайланд тусгаж хэвшихийг бүтцийн нэгж, харьяа байгууллага болон тэдгээрийн төрийн жинхэнэ албан хаагчдад,
2. Үр дүнгүй болон эрчимжүүлэх шаардлагатай үнэлгээ авсан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тодорхой шийдэл гарган хэрэгжүүлж, тайлагнахыг хариуцсан нэгж, байгууллагуудад тус тус зөвлөмжилж байна.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХШҮ-НИЙ ТАЙЛАН

### ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ 2021 оны хагас жил

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2021 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО							
1	1.1.10. Засгийн газраас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл, санхүүжилтийн эх үүсвэрийг хугацаанаас нь өмнө төлүүлэх, хямдруулан худалдах, дампуурсан банкнуудын эрх хүлээн авагчдаас авах төрийн байгууллагуудын авлагыг Монголбанканд шилжүүлэх зэргээр Засгийн газрын санхүүгийн нөөцийг нэмэгдүүлнэ.	1. Засгийн газрын бондын хөрөнгөнөөс ЖДҮХС-д дамжуулан зээлдүүлсэн зээл, МУХС-гийн хөрөнгөөр бүрдүүлсэн улаан буудайн нөөцтэй холбоотойгоор улсын төсөвт төлөх өр төлбөрийг Хөдөө аж ахуйг дэмжих сангаас төлж барагдуулна.	2020 - 2024		Засгийн газрын бондын хөрөнгөнөөс ЖДҮХС-д дамжуулан зээлдүүлсэн зээл, МУХС-гийн хөрөнгөөр бүрдүүлсэн улаан буудайн нөөцтэй холбоотойгоор улсын төсөвт төлөх өр төлбөрийг Хөдөө аж ахуйг дэмжих сангаас төлж барагдуулсан байна.	Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамтран Монгол Улсын хөгжүүлэх сангийн хөрөнгөөр бүрдүүлсэн хүнсний улаанбуудайн нөөцтэй холбогдох өр, авлагын тооцоо нийлж баталгаажуулсан. 2021 оны хагас жилийн байдлаар Хөдөө аж ахуйг дэмжих сангийн Засгийн газрын дотоод зээлийн эргэн төлөлт 11,000,000.0 мян.төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 2,500,000.0 мян.төгрөг, Мал хамгаалах сангийн Засгийн газрын дотоод зээлийн эргэн төлөлтөд 2021 оны байдлаар 1,283,836.55 мян.төгрөг, Сангийн яам, ХХААХҮЯ хооронд 2019 онд байгуулсан "Засгийн газрын бондын төлбөр барагдуулах гэрээ"-ний дагуу 2021 оны хагас жилийн байдлаар 14,383,882.2 мян.төгрөг төлөхөөс 6,785,013.2 мян.төгрөгийг улсын төсөвт төлсөн байна. 2021 оны эхний хагас жилд Мал хамгаалах сангаас зээл авсан 52 иргэн, аж ахуй нэгжээс 273,521,175, Газар тариалангийн дэмжлэгт хамрагдсан 97 иргэн, аж ахуй нэгжээс 9,995,544,418, Бага оврын тракторын дэмжлэгт хамрагдсан 82 иргэн, аж ахуй нэгжээс 111,850,016, нийт 10,380,915,609 төгрөгийн өр төлбөрийг сангийн дансанд төвлөрүүлээ. 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Мал хамгаалах сангаас зээл авсан 2 иргэн аж ахуй нэгжийн 3,304,083,200, Газар тариалангийн зээлд хамрагдсан 10 иргэн, аж ахуй нэгжийн 7,728,234,000, Бага оврын тракторын зээлд хамрагдсан 6 иргэн, аж ахуй нэгжийн 34,500,000, нийт 11,066,817,200 төгрөгийн өр төлбөрийг ХААДС-д төлөх тухай	70%

						шүүхийн шийдвэр гарч, өр төлбөрийг төлүүлэх ажиллагаа хийгдэж байна. Мөн 37 иргэн, аж ахуй нэгжийн 2,450,967,866 төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийг төлүүлэхээр шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргаад байна.	
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							
2	3.1.20. Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих "Экспортын баталгааны сан" байгуулж ажиллуулна.	1. Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих "Экспортын баталгааны сан" байгуулж ажиллуулна.	2021 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Уул уурхайн бус салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилгоор Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн хүрээнд Үндэсний Давхар Даатгал ХК-тай хамтран Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхээр 2021 оны 03 дугаар сараас даатгалын бүтээгдэхүүний судалгааны ажил эхлүүлсэн. Зөвлөхөөр Герман улсын Оффенбург их сургуулийн Худалдаа ба инновацын институтын захирал профессор Андреас Класен ажиллаж байна. Даатгуулагчид үүсэх эрсдэлээс хамгаалж олон улсын давхар даатгалын 12 компанид хамтран ажиллах хүсэлт хүргүүлж, хүсэлтийг хүлээн авсан. Олон улсын давхар даатгагч SCOR групптэй гэрээ байгуулахаар хамтран ажиллах нөхцөлийг тохиролцож байна. Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүний судалгааны ажлын баримт бичигт Олон улсын давхар даатгагчийн саналыг тусган 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр олон нийтэд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.	50%
3	3.3.1. Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангаж, бүтээгдэхүүнийг экспортлох, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, таримлын сэлгээ,	1. Газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийг эрчимжүүлж, механикжилтын түвшинг нэмэгдүүлнэ	2021 - 2024		Засгийн газар хооронд байгуулсан санамж бичиг, хэлэлцээр, гэрээний хэрэгжилтийг хангах ажлыг тухайн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.	БНБУ-ын хөнгөлөлттэй зээлийн 4,5 сая еврогоор ногоон тэжээл тариалах зориулалттай 82 морины хүчтэй трактор, хадуур тармуур, хаман боогчийн иж бүрдэл 60, төмсний үйлдвэрлэлийн ажлын зориулалттай 82 морины хүчтэй трактор, анжис, сийрүүлүүр, ухагчтай иж бүрдэл 35, хүнсний ногооны үйлдвэрлэлийн ажлыг механикжуулах зориулалттай 35 морины хүчтэй трактор, үрлүүр, ургамал хамгааллын бодис цацагчтай иж бүрдэл 20, эрчимжсэн мал аж ахуйн тэжээл тариалах зориулалттай 135 морины хүчтэй трактор, хадуур, тармуур, хаман боогчтой иж бүрдэл 10, тэжээл тариалах ажлын хөрс боловсруулалтад ажиллах зориулалттай 150 морины хүчтэй	70%

	тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.					<p>трактор 5 ширхэг, бордоо цацагч, бордоо ачих ачигч зэрэг техник худалдан авах зээлийн тусгайлсан хэлэлцээрийг Беларусын талтай байгуулсан. Техникийг 6-8 дугаар сард нийлүүлэхээс эхний техникүүдийг 6 дугаар сарын сүүлчээр хүлээн авна.</p> <p>2. БНПУ-ын хөнгөлөлттэй зээлийн 3,2 сая еврогийн эх үүсвэрээр төмс, хүнсний ногооны техник нийлүүлэгчийг сонгон шалгаруулах хоёр дахь удаагийн тендерийг 2021-07-08-ны өдөр нээх ба БНПУ-ын үйлдвэрлэгчид оролцох хязгаарлагдмал нөхцөлтэй. Захиалагчийн баталсан тендерийн баримт бичигт зааснаар 82 морины хүчтэй трактортай төмсний иж бүрдэл техник 35, 50 морины хүчтэй трактортай хүнсний ногооны иж бүрдэл техник 60, хүнсний ногооны үйлдвэрлэлд зориулсан 35 морины хүчтэй трактортай иж бүрдэл 42 ширхэгийг нийлүүлэх юм.</p> <p>3. ОХУ-ын 10,0 сая долларын зээлийн эх үүсвэрээр үр тарианы техник нийлүүлэх ажилд ХААН болон Внешэконом банк хоёр талаас санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэхээр ажиллаж байна. ОХУ-ын техник үйлдвэрлэгчид, монголын талаас хөдөө аж ахуйг дэмжих сан хамтран ажиллаж байна. ОХУ-ын үр тарианы техник лизингээр худалдан авах хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжүүдийн захиалгыг хүргүүлсэн. ОХУ болон БНХАУ-ын 240 сая төгрөгийн зүтгэх хүчний техник, тоног төхөөрөмж 682 сая төгрөгийн чиргүүл, дүүжин машин, 8.7 сая төгрөгийн бусад техик, тоног төхөөрөмжийг ААН, иргэдэд санхүүгийн түрээсийн гэрээ болон шууд худалдан авалтаар борлуулсан.</p>	
4		3. Хөрсний үржил шимийг сайжруулах, нэгжийн ургацыг нэмэгдүүлэх зорилгоор бордоог хөнгөлөлттэй	2021 - 2024		53.0 мянган га талбайд бордож ургацын хэмжээг 20 мянган тн. оор нэмэгдүүлнэ. Бордсон талбайн нэгжийн ургацыг 25 хувиар нэмэгдүүлнэ.	Манай улсад ажиллаж буй бордооны үйлдвэрийн тоо, үйлдвэрлэж буй бордооны хэмжээ, нэр төрөл болон хангамжийн талаар судалгаа гаргаж нэгтгэсэн. Мөн сүүлийн 5 жилд импортоор бордоо оруулж ирсэн бордооны хэмжээг нэгтгэн гаргаж, манай улсад жилд хэрэглэж буй бордооны нэр төрөл, тоо хэмжээ, үүнээс дотоодын үйлдвэрлээр болон импортоор хангаж буй тоо хэмжээг гаргасан ба энэхүү судалгааг үндэслэн батлагдсан төсөвт багтаан тариаланчдад хөнгөлөлттэй нөхцлөөр олгох бордоог нийлүүлэх ажлыг зохион байгуулах тухай зөвлөмжийг ХААДС-д хүргүүлсэн. ХААДС-аас 2021 оны тариалалтад зориулан батлагдсан төсөвт	100%

		нөхцөлөөр олгоно			багтаан 215 тн нийлмэл бордоо, 25 тн гумины бордоо нийлүүлэх ажлыг зохион байгуулан иргэд аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож байна.	
5		4. Энгийн болон инженерийн хийц бүхий услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлах замаар усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ	2021 - 2024	Усалгаатай тариалангийн талбайн хэмжээ 1.5 мянган га-аар нэмэгдэнэ	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх" төслөөр олгож буй усалгааны тоног төхөөрөмж зээлэр авах хүсэлт ирүүлсэн Сэлэнгэ аймгийн Сант сумын "Анар-Орд" ХХК 275 га, Орхонтуул сумын иргэн Р.Эрдэнэбилэг 100га, "Гангарант" ХХК 200 га, Баянгол сумын "Эям байгаль даваа" ХХК 54 га, Увс аймгийн Тариалан сумын "Алдар тулга" ХХК 75 га, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын "Астра рүүт" ХХК 75 га, "Мааньт-Агро"175 га, Завхан аймгийн Тэлмэн сумын "Цагаан-Уулын лүндэн" ХХК 100 га, Төв аймгийн Цээл сумын "Давхар түрүү" ХХК 100 га, Баянцогт сумын "Гуна" ХХК 100 га, Угтаал сумын "Нөмрөгийн Их хайрхан" 125 га, Баянцогт сумын "Арвин цээл" ХХК 125 га услах хүчин чадал бүхий усалгааны тоног төхөөрөмжийг зохих журмын дагуу зээлээр олгох эрх нээсний үр дүнд 1504 га талбайг усалгаатай тариалангийн эргэлтэд нэмэх боломж бүрдээд байна. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслөөр Говь-Алтай, Завхан, Ховд, Баян-Өлгий, Хэнтий, Сэлэнгэ, Төв аймгийн 11 услалтын системийг шинэчлэх, сэргээн засварлах ажлын тендерийг цахимаар 6 сарын 01-нд зарлаад байна. Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 2021 онд 26 ААН, иргэнд 3,3 тэрбум төгрөгийн үнэ бүхий усалгааны 125 га талбайн 2 ш, 100 га талбайн 4 ш, 75 га талбайн 3 ш, 300 м дамартай усалгааны системийг 3ш, 3 га талбайн намираа усалгааны системийг 12 ш, 1450 м PVC хоолойг борлуулж нийт 1007 га талбайг усалгааны системтэй болгосон байна.	70%
6		5. Өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуйнууд байгуулж	2021 - 2024	Хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулна.	"Өвлийн шилэн болон нарлаг хүлэмж байгуулах ТЭЗҮ боловсруулах" зөвлөх үйлчилгээний тендерийн техникийн тодорхойлолтыг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан БХБЯ-нд хүргүүлж тендерийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан. Тендер шалгаруулалт эхний удаа амжилтгүй	70%



		дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, импортыг бууруулна				болсон ба тендерийг дахин зарлаж хураангуй жагсаалтад багтсан оролцогчод тендерийн баримт бичгийг хүргүүлсэн, 7 сард нээж үнэлгээг хийнэ. АНУ-ын 3.0 сая ам.долларын буцалтгүй тусламжаар "Монгол улсад өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх төсөл" хэрэгжүүлэхээр 2020 онд 2 тал тохиролцсон. Энэ оны 6 сард тус улсын конгрессоор төслийн санхүүжилтийг эцэслэн баталснаа мэдэгдсэн. 20 га талбай бүхий өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах төсөл боловсруулж томоохон уул уурхайн компанийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна. БНСУ-ын ODA байгууллагын санхүүжилтээр Монгол улсад хүлэмжийн хангамжийг сайжруулж хүнсний ногооны өртгийн сүлжээг хөгжүүлэх" төсөл хэрэгжүүлэхээр 2 тал харилцан тохиролцож байгаа ба 2021 онд төслийн бэлтгэл ажил хангах, Монгол улсын хүлэмжийн үйлдвэрлэлийн нөхцөл байдлыг судлах 30.0 мянган ам.долларын судалгааны төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэж гэрээ байгуулахаар ажиллаж байна. “Зуны хүлэмж нийлүүлэх” ТШ/2021/01/ХҮ тендер шалгаруулалт зохион байгуулан 32 м <sup>2</sup> талбай бүхий 83 иж бүрдэл хүлэмжийг улсын төсвийн 148.8 сая төгрөгөөр нийлүүлж ХХААХҮ-ийн Сайдын А-151 дүгээр тушаалаар иргэд, аж ахуйн нэгжид 30 хувийн урьдчилгаатай 4 жилийн хүүгийн зээлийн гэрээгээр олгож хүлэмжийн талбайг 2656 м <sup>2</sup> -аар нэмэгдүүлэв.	
7	3.3.3. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	1. Махны нөөц бүрдүүлнэ	2021 - 2024	6500.0	Махны 20 мянган тонн хүртэл нөөц бүрдүүлсэн байна.	Засгийн газрын 2020 оны “Нөөцийн мах бэлтгэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 129, 2021 оны “Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд нөөцийн мах худалдаалахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 72 дугаар тогтоолын дагуу нийслэлийн хүн амын хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан 5 арилжааны банк (ХХБ, ХААН банк, Голомт банк, Төрийн банк, Капитрон банк)-ы эх үүсвэрээр 16 аж ахуйн нэгж нийт 11.0 мянган тн махны нөөц бүрдүүлсэн. 2020 онд худалдаалж байсан үнэ болох хонины ястай мах 6700 төг/кг, үхрийн ястай мах 7700 төг/кг, ямааны мах 6200 төг/кг үнээр 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс нөөцийн махны борлуулалтыг Нийслэлийн төвийн 6 дүүргийн 400-аад хүнсний дэлгүүрээр татварын цахим төлбөрийн баримтад тулгуурлан худалдаалав.	100%

						Өнөөдрийн байдлаар нийт 8541.0 тн, үхрийн ястай мах 2574.3 тн, хонины ястай мах 5529.9 тн, ямааны ястай мах 398.4 тн махыг хүнсний хэрэгцээнд худалдан борлуулаад байна.	
8		2. Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ	2021 - 2024	1,350.0	70 мянган тонн	Мах, махан бүтээгдэхүүний экспорт, мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөл, шаардлага, экспортын эрхтэй үйлдвэрийн тоог нэмэгдүүлэх зорилгоор ГХЯ, ЗТХЯ, МХЕГ, ГЕГ, МЭЕГ, МҮХАҮТ, СХЗГ, Бээжин, Турк, ОХУ-д суугаа ЭСЯ, Шанхай, Хөх хот, Лаос, Улаан-Үүд, Станбул, Бангкок, Ханой дахь Консулын газар болон Олон Улсын байгууллагын төлөөлөл бүхий нийт 60 хүний бүрэлдэхүүнтэй цахим уулзалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулав. 2. Махны экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, эрчимжсэн мал аж ахуйд тулгуурлан экспортын нөөц бүрдүүлэх, олон улсын мах экспортлогч сүлжээ компанийн төлөөлөгчийн газраар дамжуулан махны экспортыг нэмэгдүүлэх зураглал боловсруулж байна. 3. Хүнсний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолыг 2021.01.6-ны өдөр батлуулав. Тогтоолоор мал мах экспортлох тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 9 сарын 10-ны дотор ХАБҮЗ-д цахимаар хүргүүлж байхаар шийдвэрлэв. 4. Ковидын нөхцөл байдалтай холбоотой 2020 онд мах экспортлох тоо хэмжээний зөвшөөрөл олгосон 40 аж ахуйн нэгжийн квотын зөвшөөрлийн хугацааг 2021 оны эхний жил болгон экспортлохоор сунгав. Монгол Улсаас 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар адууны мах 8,0 мян.тн, дулааны аргаар боловсруулсан мах 13.4 мян.тн, нийт 21.4 мян.тн мах, махан бүтээгдэхүүн экспортолсон байна.	50%
9		3. Хүнсний сүлжээнд зохистой дадал, угтвар нөхцөл, удирдлагын тогтолцооны	2021 - 2024	80	Баталгаажсан байгууллагын тоо 2 /өссөн дүнгээр/	а) Хоол үйлдвэрлэлийн салбарт хэрэгжүүлэх зохистой дадлын хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төсөлд ЭМЯ, МХЕГ, НЭМҮТ-өөс ирүүлсэн саналыг тусгав. Тус төслийг 2021 оны 1 сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд <a href="https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tosol2036.pdf">https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tosol2036.pdf</a> хуудсанд байршуулж, санал авсан.	70%

		стандартыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ			<p>b) Хүнсний худалдаанд мөрдөх зохистой дадлын стандартын төсөл боловсруулж, холбогдох их дээд сургууль, мэргэжлийн холбоодоос санал авахаар бэлтгэж байна.</p> <p>в) Мөн хүнсний сүлжээнд зохистой дадал, олон улсын чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэхэд зөвлөх, сургах, баталгаажуулах, итгэмжлэх үндэсний чадавхыг сайжруулах чиглэлээр Дэлхийн банкны “Экспортыг дэмжих төсөл”-ийн нэгжтэй олон улсын болон импортлогч орны шаардлагын дагуу хүнсний сүлжээний бүх үе шатны зохистой дадлуудын зааврын төслийг боловсруулах, чанарын удирдлагын тогтолцоог сайжруулах, олон улсын түвшинд хүрсэн, чанартай баталгаажуулалтын үйлчилгээг дотоодоос авах нөхцөлийг бүрдүүлэх, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын баталгаажуулалтын болон итгэмжлэлийн байгууллагын чадавхыг бэхжүүлнэ. Төслөөс ЗДХНЗ-ын болон АДШЭЦХ-ын баталгаажуулалтын схем бүхий баримт бичгүүд, FSSC 22000, USDA organic, Halal, LWG, and OEKO-TEX зэрэг баталгаажуулалтын схемийн дагуу үйл ажиллагаа явуулах албан ёсны эрх бүхий баталгаажуулалтын байгууллагатай болох, 25-аас доошгүй ААН-д олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын удирдлагын гэрчилгээ авсан байхаар үр дүнг хүлээж байна. г) Салбарын бараа, бүтээгдэхүүний болон тогтолцооны баталгаажуулалт, итгэмжлэлийн тогтолцооны талаар Үндэсний итгэмжлэлийн төв, СХЗГ-ын Баталгаажуулалтын газартай 2 удаагийн уулзалт хийж, салбарын итгэмжлэгдсэн, мэргэшсэн баталгаажуулалтын байгууллагыг бойжуулах, чадавхжуулахад мэдээлэл, сургалт, судалгаагаар хамтарч ажиллаж байна.</p>	
10	4. Мал амьтан, ургамлын гаралтай органик хүнсийг баталгаажуулан, худалдааны түнш орнуудад	2021 - 2024		Баталгаажуулалтын байгууллага-2	<p>1. СХЗГ-ын Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газрыг Органик хүнсний бүртгэл, мэдээллийн сан <a href="http://www.organic.gov.mn">www.organic.gov.mn</a>-д итгэмжлэгдсэн хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагаар бүртгэв.</p>	70%

		хүлээн зөвшөөрүүлнэ				<p>2.“Органик хүнсний бүртгэл, мэдээллийн системд техникийн үйлчилгээ үзүүлэх тухай Сайдын тушаалыг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>3. "Зөгийн балны үйлдвэрлэлд зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар"-ыг боловсруулах, кластер байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлуулж, ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулав.</p> <p>4."Органик хүнс үйлдвэрлэгчид дэмжлэг, урамшуулал олгох журам"-ын эхний хувилбарыг боловсруулав.</p> <p>5. FiBL-ийн ирүүлсэн статистик маягтыг монгол хэл рүү хөрвүүлж, Монгол улс анх удаа дэлхийн органик үйлдвэрлэлийн статистик мэдээллийн санд мэдээллээ хүргүүлэх боломж бүрдэв. Монгол улсын мэдээлэл бүхий FiBL-ийн 2020 оны бюлетен хэвлэгдэн дэлхийн 180 гаруй улсад түгээгдэв.</p> <p>6. "Алсыг харъя, Органикийг сонгоё" уриан дор "ХАА-н салбарын тулгамдсан асуудал ба Органик хөгжил" олон улсын форум, сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05-ны өдрийг дуусталх хугацаанд зохион байгуулахаар төлөвлөсөн.</p> <p>7. Дэлхий банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Экспортыг дэмжих төсөл"-ийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсэгт “Монгол органик хүнс”гэрчилгээг импортлогч улс (БНХАУ)-д хүлээн зөвшөөрүүлэх, техникийн шаардлагыг дүйцүүлэх, IFOAM (International Federation of Organic Agriculture Movements)-д гишүүнээр элсэх, IFOAM-ын магадлан итгэмжлэлийн хөтөлбөрт “Монгол органик хүнс” баталгаажуулалтын схем эзэмшигчийг хамруулах санал хүргүүлж, дэмжигдэв.</p> <p>8. Органик хүнсний бүртгэл мэдээллийн санг E-Mongolia вэб порталд холбох, орон нутагт органик хүнсний давтан баталгаажуулалт, бүртгэлийг гар утасны аппликейшн ашиглах санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэв.</p>	
--	--	---------------------	--	--	--	---	--

11		7. Тослог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх, тосны үйлдвэрийн түүхий эдийн чанар, хангамжийг сайжруулна	2021 - 2024	6,600.0	60.0 мянган га талбайд тослог ургамал тариалахаас төрийн дэмжлэгээр 230 тн тослог ургамлын үр импортоор нийлүүлж 38.0 мянган га талбайд тариалах боломжийг бүрдүүлнэ. Нийт 48 мян. тн ургац хураан авна. Үйлдвэрийн хэрэгцээний 50 хувийг дотоодын ургацаас хангана.	Тослог ургамал тариалах аж ахуйн нэгжүүд 1125 га-д тариалах үрийг импортоор оруулж ирсэн байна. Тослог ургамлын үрийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2021 оны 07 сарын 01-ний өдрийг хүртэл чөлөөлөх тухай хуулийг УИХ-аар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	30%
12	3.3.4. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн	1. Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулна	2021 - 2024	-	Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж 5 байгуулна. (24%)	Улсын хэмжээнд мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний чиглэлээр бие даан үйл ажиллагаа явуулж буй 21 аймаг, нийслэлийн 118 сум, дүүргийн 139 нэгж байна. Аймаг, нийслэлийн Засаг даргын ХХААХҮ-ийн Сайдтай байгуулах үр дүнгийн гэрээнд 5 аймагт тус бүр 1 нэгж шинээр байгуулахаар тусган ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь төслийн хүрээнд Говь-Алтай аймгийн Хөхморьт, Ховд аймгийн Дарви сумдад малчдын хоршоог түшиглэн Мал үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний 2 нэгж шинээр байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Мөн Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжүүдийг дэмжих зорилгоор "Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлын төсвийн хуваарийг батлах тухай" ХХААХҮ-ийн Сайдын 2021 оны А-45 дугаар тушаалын дагуу хэрэгжүүлж буй үзлэг, ангилалтад хаврын технологит хугацаанд 66 нэгжтэй гурвалсан гэрээ	100%

	ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, "Монгол мал-II" арга хэмжээг хэрэгжүүлнэ.					байгуулж, 166.2 мянган бог малд үзлэг, ангилалт явуулж, цөм сүргийн шаардлага хангасан малыг удам зүйн үнэлгээнд оруулах, гойд ашиг шимт малаар шалгарсан малыг үржилд зориулан бойжуулах, борлуулах эрхийг цөм сүрэг бүхий өрх, аж ахуй нэгжид олгож ажиллалаа.	
13	3. Орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийг шинээр бий болгох, хил заагийг баталгаажуулах, ашиглалт хамгаалалтыг сайжруулна	2021 - 2024	150.0	Отрын нөөц бэлчээрийн өсөлт 3.3 сая га (10 %)	Орон нутгийн тусгай хэрэгцээний сум дундын отрын бүс нутгийн бэлчээрийн судалгаа хийх, бэлчээрийн хэв шинжийг тодорхойлох, отрын бэлчээрийн хилийн заагийг баталгаажуулж газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд оруулах, тухайн орон нутгийн тусгай хэрэгцээний сум дундын отрын бэлчээр ашиглалтын талаар авах арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны А/153 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, "Ногоон алт малын эрүүл мэнд" төсөл, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны төлөөлөл бүхий ажлын хэсэг Архангай, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар аймагт газар дээр нь ажиллаж, аймаг, сумдын удирдлагатай уулзалт зохион байгуулсан. Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Ховд аймгийн Газрын харилцаа, зурагзүй, геодезийн газартай орон нутгийн тусгай хэрэгцээний сум дундын болон сумын отрын нөөц нутаг бий болгож, хил заагийг баталгаажуулах гэрээ байгуулж, хийгдсэн ажлыг хүлээн авч гэрээг дүгнэсэн. Аймгуудтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж ажилласны үр дүнд нийт 234.55 мянган га бэлчээрийг сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор сумын отрын нөөц нутаг болгон тогтоож хил заагийг тодорхойлсон. Мөн 238.0 мянган га бэлчээрийг отрын нөөц нутаг болгохоор Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан хэлэлцүүлэхэд бэлтгэсэн. Ингэснээр 2021 оны эхний хагас жилд, нийт 472.5 мянган га талбайгаар орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц нутаг нэмэгдэж, цаг хүндэрсэн үед болон өвөл, хаврын улиралд ашиглах, малын зүй бус хорогдлыг бууруулах боломж бүрдүүлж, орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц нутгаар бүртгэгдсэн	100%	

						бэлчээрийг ашиглах, хамгаалах загвар журмын төслийг Бодлого судлалын төв ТББ гэрээний дагуу боловсруулж орон нутагт хүргүүлэхэд бэлэн болголоо.	
14	4.1. Уст цэг тогтоох хайгуул судалгаа, инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулна	2021 - 2024	85,0	200 цэгт уст цэгийн хайгуул хийсэн байна.	2021 онд 200 цэгт уст цэгийн хайгуул хийсэн байхаар төлөвлөсөн. Сайдын 2021 оны А/34 дүгээр тушаалд 210.0 сая төгрөг батлагдсан боловч төсөв хойшлогдсонтой холбоотой зарим арга хэмжээний мөнгөн дүн өөрчлөгдсөн. ХХААХҮ-ийн 2021.06. 22-ны өдрийн А-180 дугаар тушаалаар А-34 дүгээр тушаалд дараах өөрчлөлт орсон. Үүнд: ХХААХҮ-ийн сайдын 2021 оны А-34 дүгээр тушаалын ХХААХҮ-ийн салбарт 2021 онд төвлөрсөн арга хэмжээ болон хөрөнгө оруулалтын санхүүжилтээр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтын 16 дугаарт заасан "Бэлчээрт уст цэг тогтоох газрын доорх усны хайгуулын ажил, 210,000.0 мянган төгрөг" гэснийг "Ховд аймагт бэлчээрт уст цэг тогтоох газрын доорх усны хайгуулын ажил" 85,000.0 мянган төгрөг" гэж өөрчилсөн. Тушаал гарсантай холбогдуулан Ховд аймгийн Алтай, Буян, Булган, Дарви, Дөргөн, Дуут, Зэрэг, Манхан, Мөнххайрхан, Мөст, Мянгад, Эрдэнэбүрэн, Үенч, Ховд, Цэцэг, Чандмань сумдын 82 бэлчээрт геофизикийн хайгуул судалгаа явуулах хүсэлт ирүүлснийг нягтлан зун, намрын улирлын 68 бэлчээрийн газарт хайгуул судалгаа явуулахаар тендерийн баримт бичгийн төслийг үнэлгээний хороогоор хэлэлцэн хязгаарлагдмал тендер зарласан. Тендерийг 06 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авч үнэлгээний хорооны хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Эхний хагас жилд 68 бэлчээрт уст цэг тогтоох хайгуулын ажил хийгдэнэ. Сүүлийн хагас жилд 100 гаруй уст цэг тогтоох ажлыг улсын төсвийн болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулна.	50%	
15	4.2. Уст цэг тогтоох хайгуул судалгаа, инженерийн хийцтэй худаг	2021 - 2024	1637,0 /Улсын төсөв/ 1242.0 /ЗЗББУХНС Төсөл/	Инженерийн хийцтэй 50 худаг шинээр байгуулж, 40 мянган толгой малыг усаар хангах	"Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт" төслийн 1 тэрбум 242 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Архангай, Дундговь, Өвөрхангай, Хэнтий, Дорнод аймагт бэлчээрийн усан хангамжийн зориулалттай инженерийн хийцтэй 54 худаг шинээр гаргах тендерийг орон нутагт зохион байгуулж, ажлыг эхлүүлээд байна. Мөн АХБ-ны "Хөдөө аж ахуй, хөдөөгийн	50%	

		шинээр барьж байгуулна			боломж бүрдсэн байна.	хөгжил нэмэлт санхүүжилт" төслийн хөрөнгө оруулалтаар 2020 онд гэрээ байгуулсан Дундговь, Говьсүмбэр, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Булган аймагт шинээр гаргах худгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн гэрээг дүгнэн, үлдэгдэл санхүүжилтийг олгох ажлыг төслийн нэгжтэй хамтран зохион байгуулав. Улсын төсвийн 1 тэрбум 637 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн сумдад бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 60 гаруй инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах ажлын тендерийг аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж байна. Орон нутгаас ирүүлсэн "Худгийн тоо, ашиглалтын 2020 оны тайлан"-г нэгтгэв. 2020 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Ховд аймаг дахь Баяннуруу, Говь-Алтай аймаг дахь Аргалант, Говьсүмбэр аймаг дахь Малах отрын бүс нутагт бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор инженерийн хийцтэй 5 ширхэг худаг гаргахаас Говь-Алтай аймаг дахь Аргалантын отрын бүс нутагт гаргах 2 ширхэг худаг гүйцэтгэгч байгууллагаас шалтгаалан хийгдээгүй тул гэрээг сунган 2021 онд гүйцэтгүүлэхээр ажиллаж байна.	
16		5. Тариалангийн бүс нутгийг түшиглэн сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйг бий болгоно	2021 - 2024		Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймагт нийт 3000 үнээтэй 5 аж ахуйг байгуулна.	Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийн тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг түшиглэн нийт 3000 үнээтэй сүүний чиглэлийн үхрийн 5 аж ахуйг 91.0 тэрбум төгрөгөөр Беларусь улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлнэ. Уг төслийн хүрээнд жилдээ 18.3 сая литр сүү нийлүүлнэ. 2020 онд сонгон шалгаруулалт зарлаж (Номун Тал ХХК, Газар-Агро ХХК, Мөнх-дэмжинэ ХХК, Орхон ХХК, Момо-Агро ХХК, Даваанбулаг ХХК)-ийг төсөл хэрэгжүүлэгчээр сонгон, 3 аж ахуйн нэгжийн төслийг хэрэгжих боломжтой аж ахуйн нэгжийн нөөцөд авсан. Шалгарсан аж ахуйн нэгжүүд ферм барих газрын хөрсний геодизийн шинжилгээ хийлгэсэн, ферм барих барилгын аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хийгдэж байна. 2021 оны 6 дугаар сарын эхээр яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун Беларусь улсын холбогдох албаныхантай уулзалт, хэлэлцээ хийсэн. Тариалангийн бүс нутагт тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж төрөлжүүлэх, уг бүс нутагт зөвхөн	70%



					эрчимжсэн мал аж ахуй эрхлэх зорилгоор ХХААХҮ-ийн Сайдын ажлын хэсэг 2020 оны 9 дүгээр сард Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн малчид болон тариаланчидтай уулзалт зохион байгуулж, нөхцөл байдлыг газар дээр нь судалсан. Цаашид энэ бүс нутаг дахь бэлчээрийн мал аж ахуйг эрчимжүүлэх бодлого боловсруулж байна. ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А-03 дугаар тушаалаар “Тариалангийн бүсээс уламжлалт мал аж ахуйг шилжүүлэх, Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан эрхлэх төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах” ажлын хэсгийг байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн 17 сумын 56 баг, Дархан-Уул аймгийн 4 сумын 14 багийн нутгийг тариалангийн бүс болгон чөлөөлөх, бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийг нүүлгэн шилжүүлэх, соён гэгээрүүлэх, мал сүргийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө гаргах, үе шаттай хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн мэргэжлийн байгууллага, аймаг, сумдад чиглэл хүргүүлэн ажиллав.	
17		7. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор бог малыг шахан бордох төвийг орон нутагт туршина	2021 - 2024	ТЭЗҮ боловсруулна.	ТЭЗҮ боловсруулах ажил төлөвлөсөн боловч санхүүгийн боломжоос шалтгаалан түр хугацаанд хойшлогдоод байна. Энэ асуудлаар холбогдох төсөл, хөтөлбөрүүдтэй санал солилцож байна. ХХААХҮ-ийн судалгаа, хөгжлийн төв нь ХААИС, “Ногоон алт-Малын эрүүл мэнд төсөл”-тэй хамтран 2021 оноос Төв аймгийн Борнуур, Сүмбэр сумдад тус бүр 300, нийт 600 толгой эр хургыг төөнөх аргаар хөнгөлж, шахан бордох туршилтыг хийхээр төлөвлөж байна. - ХХААХҮ-ийн судалгаа, хөгжлийн төв болон ХААИС-ийн хамтарсан ажлын хэсгийг байгуулан “Монгол малын махны брэнд хөгжүүлэлт” судалгааны ажлыг энэ оны 03 дугаар сараас эхлэн хийж байна. Ажлын хэсгийн төлөвлөгөөг батлуулж, судалгаа, шинжилгээний ажлуудыг хийж байна.	30%
18	3.3.5. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, сайжруулалтын	1. Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж байгаа мэрэгч	2021 - 2024	Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготно, царцаатай 1.6 сая	ХХААХҮ-ийн сайдын хуваарь батлах тухай 2021 оны А/76 дугаар тушаалын дагуу хавар, намрын улиралд уг арга хэмжээг зохион байгуулна. Хаврын арга хэмжээнд Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай аймгийн 34 суманд микробиологийн	100%

	хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна.	амьтад, шавжтай байгаль орчинд сөрөг нөлөө багатай аргаар тэмцэнэ		га-гаас багагүй талбайд байгаль орчинд сөрөг нөлөө багатай аргаар тэмцэх ажил зохион байгуулсан байна.	аргаар 4 дүгээр сарын 20-ноос 5 дугаар сарын 15-ны өдрүүдэд MNS:6866-2020 улсын стандартын дагуу зохион байгуулж дууслаа. Үлийн цагаан оготнотой тэмцэх ажилд шаардлагатай микробиологийн бэлдмэлийг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар худалдан авч ХХААХҮ-ийн сайдын А/76 дугаар тушаалаар хуваарилагдсан аймгуудад хүргүүлэн тэмцэх ажилд ашиглалаа. Микробиологийн бэлдмэлийн чанар, эрүүл ахуйн байдалд Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори дүгнэлт гарган бусад бүлээн цуст амьтдад халгүй болохыг баталгаажуулсан. Дээрх 5 аймгийн ХХААГ-т микробиологийн бэлдмэлийг ашиглан үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг хэрэгжүүлэх, үр дүнг баталгаажуулах, тайлагнах талаарх удирдамжийг хүргүүлэн мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллав. Ийнхүү үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хаврын улиралд зохион байгуулснаар нийт 100 гаруй мянган га бэлчээрийн ургамлыг мэргэч амьтны хөнөөлөөс хамгаалж мал аж ахуйн үйлдвэрлэлд хэвийн ашиглах боломжийг бүрдүүлсэн. Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлснээр зун, намрын улирлын бэлчээрийн малын тэжээлийн нөөцийг 122040 мянган тонноор нэмэгдүүлэв. Уг ургамал хамгааллын арга хэмжээний техникийн үр дүнг баталгаажуулах, хэрэгжилтэд мэргэжлийн хяналт хийж ажиллах тухай МХЕГ-ын даргын 2021 оны 01/78 дугаар удирдамжийг холбогдох аймгуудын хяналтын газарт хүргүүлсний дагуу аймгуудын ургамал хамгаалал, цорио цээрийн улсын байцаагч, сумдын байгаль орчны улсын хяналтын байцаагч нар хяналт тавин, дүгнэлтийг аймгийн ХХААГ-т хүргүүлж байна.	
19	3.3.6. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд	1. Малчдын анхдугаар аяныг зохион байгуулна	2021 - 2024	Зөвлөгөөн хийж, аяныг эхлүүлэх	"Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх, малчдын залуу халааг бэлтгэх" зорилтын хүрээнд Малчдын анхдугаар аяныг зохион байгуулахаар Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэж байна. Малчдын анхдугаар аяныг 8 дугаар сард зарлаж зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн ХНХЯ, ОУХБ-тай хамтран "Малчин мэргэжлийн сургалтын хөтөлбөр, стандартыг боловсруулах" бэлтгэл ажлын хүрээнд Үндэсний	30%

	боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг				хэмжээнд Малчин мэргэжлийн лавлахыг баталгаажуулах ажлыг хийж байна. ХХААХҮЯ-ны дэргэд Малчин лавлах-109 мэдээллийн төвийг тогтмол ажиллуулж малчдаас санал хүсэлт авах, цаг үеийн мэдээ мэдээллийг шуурхай түгээх, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах ажлыг зохион байгуулж байна.	
20	үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	2. "Монгол малчин" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021 - 2024	Малчин өрхийн үйлдвэрлэлийн хэмжээ 10-аас доош хувиар өснө. малчин өрхийн жилийн дундаж орлого 10-аас доошгүй хувиар нэмэгдэнэ.	Малчдыг дэмжих зээлийн 20542 хүсэлт ирснээс 1665 зээлийг татгалзаж, 3423 нь судалгаанд байгаа бол 15454 зээлдэгчид зээл олгосон. Ингэснээх 230.3 тэрбум төгрөгийн хүсэлтээс 22.1 тэрбум төгрөгийн зээлийг татгалзаж, 42.3 тэрбум төгрөгийн зээл судалгаанд байгаа бол 157.6 тэрбум төгрөг олгосон. Засгийн Газрын 2021 оны 110 дугаар "Мал аж ахуйн салбарын хаваржилтын хүндрэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Дэлхийн банкны "Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх" төслийн санхүүжилтээр 21 аймгийн 330 суманд ажиллаж амьдарч буй 176966 малчин өрх тус бүрд 100 мянган төгрөгийн дэмжлэг буюу нийт 17,696,600,000,0 төгрөгийг Төрийн сангаар дамжуулан шилжүүлэх ажлыг зохион байгуулсан. 2021 оны 3-р дугаар сард сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн 1,897,521 литр үнээний шингэн сүү бэлтгэн нийлүүлсэн 1724 малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд 948,760,500 төгрөгийн мөнгөн урамшууллыг төрийн сангийн дансаар дамжуулан шилжүүлсэн. Үндэсний 83 үйлдвэр, цехэд 2020 онд хонь, тэмээний ноос бэлтгэн нийлүүлсэн 90,064 малчин, мал бүхий этгээдэд 31.2 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллын баримт бүртгэгдсэн. Үүнээс журмын шаардлага хангасан 78 үйлдвэрт 18,566.3 тонн хонины ноос, 676.2 тонн тэмээний ноос бэлтгэн нийлүүлсэн 88,669 малчин, мал бүхий этгээдэд 30.7 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллыг малчдын дансанд шилжүүлээд байна. Монгол улсын нийгэм эдийн засгийн байдлын 2020 оны судалгаагаар Улсын хэмжээнд мал тооллогын урьдчилсан дүнгээр 242.0 мянган малтай өрх тооллогод хамрагдаж, өмнөх оноос 8.7 мянган өрхөөр буюу 3.7 хувиар өссөн байна. 2020 оны дүнгээр малчин өрхийн 81.7 хувь нь цахилгааны	50%

					эх үүсгүүртэй, 72.5 хувь нь телевизортой, 52.2 хувь нь автомашинтай, 48.9 хувь нь мотоциклтой байна.		
21	3.3.7. Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдыг өвс тэжээл нөөцлөх сүлжээг бий болгоно.	1. Өвсний нөөц бүрдүүлэх, зориулалттай техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийнэ	2021 - 2024		Хөвсгөл аймагт өвсний нөөц бүрдүүлнэ.	Малын тэжээл тариалах, нөөц бүрдүүлэх төсөл хэрэгжүүлэх хүрээнд Хөвсгөл аймгийн Жаргалант, Галт, Цэцэрлэг, Цагаан-Уул, Улаан-Уул, Их-Уул суманд өвсний нөөц бүрдүүлэх зориулалттай техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Дээрх 6 суманд тус бүр 1 хадлангийн иж бүрдэл нийлүүлэгдэнэ.	50%
22	3.3.8. Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ.	1. Биокомбинат үйлдвэрийн дэд бүтэц, үйлдвэрийн технологийг шинэчлэнэ	2021 - 2024		4,000 кв үйлдвэрийн барилга, BSL-3 (Био-аюулгүйн 3-р зэрэглэл) зэрэглэлийн лаборатори баригдсан байна.	Гэрээний үе шатны ажлын хуваарийн дагуу 2020 онд барилга буулгах ажлыг төлөвлөж, 2020 оны 11-р сарын 06-ны өдрөөс төслийн ажлыг эхлүүлж барилга буулгалтын ажил дууссан. 2. Шүлхий, бог малын мялзан өвчнөөс сэргийлэх вакцин үйлдвэрлэлийн дамжлага, технологи, схем, тоног төхөөрөмжийн байршлын схем, концепци боловсруулсан. 3. Үйлдвэрлэлийн болон биоаюулгүй ажиллагааны 3, 2 дугаар зэрэглэлийн лабораторийн үйл ажиллагааны схем, төлөвлөлт, концепц боловсруулсан. Барилгын зураг төсвийг Унгарын тал Италийн гүйцэтгэгчээр бэлтгүүлж 2021 оны 2 дугаар сарын 23-ны өдөр ирүүлсэн. Уг зураг төсөв гэрээний техникийн үзүүлэлтэд тохирсон тохиолдолд Монгол улсын стандартад нийцүүлэх ажил хийгдэнэ. 4. Үйлдвэрийн, биоаюулгүй ажиллагааны 3, 2 дугаар зэрэглэлийн лабораторийн тоног төхөөрөмжийн нарийвчилсан үзүүлэлтийг гаргасан. ХХААХҮ-ийн сайдын 2021 оны А-65 дугаар тушаалаар Биокомбинат ТӨХХК-ийн шинэчлэлийг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулсан. БННУ-ын төслийн гүйцэтгэгч Мега-ложистик компаниас 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр 2 мэргэжилтэн Монгол улсад ирж ажиллаж байна. Биокомбинат үйлдвэрийн өргөтгөлийн барилга, байгууламжийн зураг төсөл, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх түлхүүр гардуулах нөхцөлтэй ВЕР/2019/09-22 тоот гэрээ"-нд	30%

					оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг англи, монгол хэл дээр боловсруулан БНУУ-ын талд хүргүүлээд байна.	
23	2. Малын эмч нарыг чадавхижуулж, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулна	2021 - 2024		Сум, дүүргийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн чадавхын суурь судалгааг шинэчилж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байна.	Судалгаанд үндэслэн мал эмнэлгийн нэгдсэн системд бүртгэлтэй боловч сүүлийн 2 жил үйл ажиллагаа явуулаагүй, давхар, буруу бүртгэгдсэн 119 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг системд хасалт хийсэн. Төрөлжсөн болон тусгай мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг мал эмнэлгийн нэгдсэн системийн бүртгэлд оруулж, гэрээт үйлдвэр, хүнсний зах, худалдааны төвүүдтэй холболтыг хийснээр мал эмнэлгийн магадлан шинжилгээний гэрчилгээ бичих нөхцөл хангасан. Мал эмнэлгийн нэгдсэн системд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандартын үзлэг хийх 5 төрлийн 328 асуумжийг боловсруулан, мал эмнэлгийн нэгдсэн системд байршуулан, стандартын үзлэг эхлүүлсэн. Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих 04 тоот удирдамж боловсруулан хүргүүлж, нэгдсэн арга зүй удирдлагаар хангасан. Мал эмнэлгийн нэгдсэн системд байршуулан судалгааг авч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн суурь судалгааг шинэчлэн гаргасан.	90%
24	3. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ (Мал, амьтны гоц халдварт болон зооноз өвчнөөс бусад)	2021 - 2024	Орон нутгийн төсөв	Мал, амьтны халдварт өвчний голомт, тохиолдлын тоо суурь оноос 0.5-аас доошгүй хувиар буурсан байна.	Төлөвлөгөөт дархлаажуулалтын төлөвлөгөөг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/48 дугаар тушаалаар баталгаажуулан аймгуудад цахимаар хүргэсэн. Тус төлөвлөгөөний дагуу дархлаажуулалтад шаардагдах вакциныг орон нутагт хуваарийн дагуу хүргэж байна. Үүнд: Улсын төсвөөр санхүүжих өвчнөөс сэргийлэх вакцин 77,6, орон нутгийн төсвөөр санхүүжих өвчнөөс сэргийлэх вакцин 62,3, иргэдээс санхүүжих өвчнөөс сэргийлэх вакцин 93,6 хувийн гүйцэтгэлтэйгээр орон нутагт хүргэгдсэн. Улс болон орон нутгаас санхүүжүүлэх дархлаажуулалтын арга хэмжээнд шаардагдах зарим вакцины тарилга 8-10-р сард таригдахтай холбоотойгоор гүйцэтгэлийн хувь бага буюу 33,9 хувьтай байна. Улсын хэмжээнд хагас жилийн байдлаар халдварт өвчний дуудлага 1097 бүртгэгдсэн.	50%

25		4. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлнэ	2021 - 2024	Улсын төсөв - 8,456.80 сая төгрөг.	Өвчингүй, тайван байдлыг хангах, өвчин бүртгэгдсэн үед шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэн голомтыг устгасан байна.	Шүлхий, бог малын мялзангаас сэргийлэх яаралтай дархлаажуулалтын төлөвлөгөөг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/51 дүгээр тушаалаар баталгаажуулан холбогдох аймгуудад хүргүүлсэн. Шүлхий, бог малын мялзангаас сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах вакциныг гадаад улсаас худалдан авах ажил хийгдэж байна. Хонины цэцгээс сэргийлэх вакцины үйлдвэрлэл Биокомбинат УТҮГ-т хийгдэж байна. Байнгын ажиллагаатай хилийн боомт бүхий Дорноговь, Дорнод, Сүхбаатар аймагт 2021 оны 3 дугаар сараас эхлэн малын гоц халдварт шүлхий өвчний дуудлага ирж, лабораторийн шинжилгээгээр баталгаажиж, өвчнийг таслан зогсоох арга хэмжээг Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны А/187 дугаар тушаалаар баталсан “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар”-ын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. Он гарсаар Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн 9 сумын 10 голомтод 16 малчин өрхийн 114 үхэр, 175 хонь, нийт 313 толгой мал өвчилсөн ба одоогоор Хэнтий аймгийн Галшар, Дархан, Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Дорноговь аймгийн Их хэт, Айраг сумдын нутаг дэвсгэрт хорио цээрийн дэглэм хэрэгжиж байна. Шаардагдах вакцины тендер, үйлдвэрлэгчийн үйлдвэрлэлийн боломжоос шалтгаалан ОХУ-аас 6 дугаар сарын 18-нд эхний ээлжийн 1,6 сая тун вакциныг хүлээн авч Улаанбаатар, Дундговь, Төв, Өмнөговь аймагт хамгаалалтын бүс үүсгэн вакцинжуулахаар хуваарилан олгож 6 дугаар сарын 20-ны өдрөөс хэрэгжүүлж байна. ОХУ-аас вакцин нийлүүлэгдэх хүртэл хугацаанд МЗЭГ-т хадгалагдаж буй нөөц шүлхийн вакцинаар хилийн боомттой бөгөөд байнгын автотээврийн хөдөлгөөн хийгддэг бүс болох Дорнод аймгийн Халхгол, Матад, Дорноговь аймгийн Хатанбулаг, Сүхбаатар аймгийн Онгон, Дарьганга, Халзан, Баяндэлгэр, Хэнтий аймгийн Галшар сумдын голомтын болон сэжигтэй бүсийн 999,4 мянган толгой мэдрэмтгий мал сүргийг дархлаажуулах арга хэмжээг хэрэгжүүлээд байна.	50%
----	--	--	-------------	------------------------------------	---	--	-----

26		5. Малын бруцеллэз, боом, галзуу зэрэг зооноз өвчнөөс урьдчилан сэргийлнэ	2021 - 2024	2,987.40 сая төг	Зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэрэгжүүлж бруцеллэзын халдварын түвшин 0.02, галзуу, боом өвчний голомтын тоо 1 хувиар тус тус буурсан байна.	Төлөвлөгөөт дархлаажуулалтын төлөвлөгөөг МЭЕГ-ын даргын 2021 оны А/48 дугаар тушаалаар баталгаажуулан аймгуудад цахимаар хүргэсэн. Дархлаажуулалтад шаардагдах вакциныг орон нутагт хуваарийн дагуу хүргүүлж байна. Үүнд: Боом өвчнөөс сэргийлэх вакцин 3,2 сая тун орон нутагт хүргэхээс 2,9 сая тунг хүргэж гүйцэтгэл 88,0 хувьтай байна. Галзуу, бруцеллэз өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтыг 8-10-р сард тарихаар төлөвлөсөн бөгөөд вакцины үйлдвэрлэлийн ажил хийгдэж байна. Галзуу өвчнөөс сэргийлэх вакцины үйлдвэрлэлээс 1 цуврал буюу 147 мянган тун вакцин шалгалтаас гарсанг аймаг, нийсэлэлд хуваарилаад байна. Улсын хэмжээнд халдварт өвчний дуудлага хагас жилийн байдлаар 1097 бүртгэгдсэн. Үүнээс галзуу өвчний 23, боом өвчний 8 тохиолдол батлагдсан байна. Бруцеллэзын халдварлалтын түвшин тогтоох тандан судалгааны ажлын бэлтгэл хангаж байна.	50%
27		6. Мал эмнэлэг, хүнсний аюулгүй байдлын лаборатори, чанарын дэд бүтцийг сайжруулах, чадавхижуулна	2021 - 2024		Мал эмнэлэг, хүнсний аюулгүй байдлын байгууллагын лабораторийг шинэчилсэн байна /лабораторийн тоо 4/	Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Мал эмнэлгийн лабораторийн барилгыг шинэчлэн барих ажлын гүйцэтгэл 60.0 хувьтай байгаа бөгөөд 2021 оны 9-р сард хүлээн авахаар ажиллаж байна. Мөн уг төслийн санхүүжилтээр Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн лабораторийн барилгын ажлыг шинэчлэн барихаар шавыг тавин барилгын ажлыг эхлүүлээд байна. Тус барилгыг 2022 оны 1-р сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн.	50>...>30
28		7. Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон, үхрийн тархи сархиагтах өвчингүй, тайван байдлыг ДМАЭМБ-аар баталгаажуулна	2021 - 2024		Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон өвчингүй, тайван болохыг баталгаажуулах хүсэлтийг ДМАЭМБ-д өргөн мэдүүлсэн байна.	1.Монгол улс үхрийн цээж өвчингүй болохыг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэх тайлан, доссиер бэлтгэх ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, зардлын төсвийг Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны А/61 дүгээр тушаалаар баталж, жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, доссиерын материалыг бэлтгэж байна. Доссиерийн материалыг 2021 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад илгээхээр төлөвлөн бэлтгэж байна. 2. Үхрийн тархи сархиагтах өвчний тандалт судалгааг 2011 оноос УМЭАЦТЛ-т, ямааны годрон өвчний тандалт судалгааг 2018 оноос Мал	70%

					эмнэлгийн хүрээлэнгийн судлаачид жил бүр хэрэгжүүлж, Монгол улс эдгээр өвчнөөр тайван байдлаа баталгаажуулан, нийтэд мэдээлэх зорилгоор үр дүнг нэгтгэж байна.	
29		8. Шүлхий өвчингүй, тайван байдлыг баталгаажуулна	2021 - 2024	16.0 сая төг - Дэлхийн банкны санхүүжилттэй Мал аж ахуйн эдийн засгийн эрэлтийг нэмэгдүүлэх төсөл	Баруун бүсийн 7 аймгийн газар нутгийг шүлхий өвчингүй, вакцин тарьдаггүй бүсээр баталгаажуулах хүсэлтийг ДМАЭМБ-д өргөн мэдүүлсэн байна.	70%
30	3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ.	2021 - 2024	Төсөл хэрэгжүүлэхэд санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх	Гааль болон НӨАТ-аас чөлөөлөх ээрэх үйлдвэрийн тоног төхөөрөмжийн жагсаалт гаргасан. 2. Үндэсний хөгжлийн газраас Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах гэж байгаатай холбогдуулан ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэхэд санхүү хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх хүрээнд ээрэх үйлдвэрийн төслийн мэдээллийг ирүүлсэн маягтын дагуу боловсруулан. 3. Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх хүрээнд Засгийн газраас 2021 онд хэрэгжүүлэх 100 төслийн жагсаалт батлагдсаны дагуу холбогдох тооцоо судалгааг гарган Сангийн яаманд хүргүүлсэн.	30%
31	3.3.10. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж,	1. "Дархан арьс ширний цогцолбор" үйлдвэрлэл, технологийн	2021 - 2024	ҮТП-ийн дэд бүтцийн ажлын явц 70 хувь	МУЗГ-ын 2020 оны 234 дүгээр тогтоолоор "Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт" ТӨХХК-ийн дүрэм баталж, ХХААХҮ-ийн Сайдын 2021 оны А-40 дүгээр тушаалаар хувьцаа эзэмшигчийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх "Орон тооны бус зөвлөл" байгуулсан. Хувьцаа эзэмшигчийн 2021 оны 03 дугаар	50%



	хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	парк(ҮТП)-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ				сарын 05-ны өдөр зохион байгуулсан анхдугаар хуралдаанаас ТУЗ байгуулах, ТӨХХК-ийн гүйцэтгэх удирдлагыг томилох тухай удирдамж ирүүлсний дагуу 03 дугаар сарын 11-ний өдөр хуралдаж, Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК-ийн төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх ТУЗ, гүйцэтгэх удирдлага, компанийн бүтэц зохион байгуулалт, орон тоо, төсөв, ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг түр томилох, нэр дэвшүүлэх түр хороог байгуулах, компанийн бэлгэдэл, хэвлэмэл хуудас, барааны тэмдэгийн загвар гаргах зэрэг асуудлыг хэлэлцэн баталсан. Дэлхийн банкны санхүүжилтээр Дархан арьс ширний цогцолборын ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулахаар 2021.01.07-22-ны өдрүүдэд Дэлхийн банкны холбогдох төлөөлөлтэй цахим уулзалтуудыг зохион байгуулж, ХХААХҮЯ-ны зүгээс мэргэжлийн чиглэлээр мэдээлэл солилцож хамтран ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А-37 дугаар тушаалаар байгуулсан. ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг 5 дугаар сард батлан ажлыг эхлүүлсэн. Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх хүрээнд Засгийн газраас 2021 онд хэрэгжүүлэх 100 төслийн жагсаалт батлагдсаны дагуу холбогдох тооцоо судалгааг гарган Сангийн яаманд хүргүүлсэн. Дархан арьс ширний цогцолборын ноос боловсруулах үйлдвэрийн барилгын ажил 86 хувь, дэд станцын угсралт 95 хувь, бохир ус цэвэрлэх байгууламжийн барилгын ажил 80 хувь, дотор дулааны шугамын ажил 70 хувь, богийн арьс шир боловсруулах үйлдвэрийн барилгын суурийн ажил 18 хувь, уур гаргах үйлдвэрийн барилгын суурийн ажил 18 хувийн гүйцэтгэлтэй байна.	
32		3. Түүхий эд бэлтгэлийн зориулалтаар хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн нэн хөнгөлөлттэй зээлийг Аж ахуй	2021 - 2024		Экспортын хэмжээг 5 хувиар нэмэгдүүлнэ.	2021 оны ноолуур бэлтгэлтэй холбогдуулан шаардлагатай судалгаа, өмнөх жилүүдийн зээлийн мэдээллийг гаргаж удирдлагад танилцуулан, ноолуур бэлтгэхэд шаардлагатай 200 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр Монгол Улсын Хөгжлийн банктай уулзалт зохион байгуулж, санал солилцсон. 2. Засгийн газрын 2021 оны 42, 3 дугаар сарын 10-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөөний 2.5-д ноолуур бэлтгэлийг дэмжих зорилгоор 200 тэрбум төгрөгийг	70%

		нэгжүүдэд олгоно.				арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан жилийн 3 хувийн хүүтэй зээл олгох, уг зээлд хамрагдсан аж ахуйн нэгжид Засгийн газраас 7.65 хувийн хүүгийн дэмжлэг үзүүлэхээр тусгуулан батлуулсан. Хас банк, Капитрон банк, Төрийн банк, Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банктai санхүүжилтийн гэрээ байгуулсан. Арилжааны банкуудад 2021 оны хагас жилийн байдлаар ноолуур бэлтгэлийн зээлийн 253.4 тэрбум төгрөгийн хүсэлтээс 20 аж ахуйн нэгжид 49.1 тэрбум төгрөгийг олгож, 3 аж ахуйн нэгж 11,1 тэрбум төгрөгийн зээлийн дахин санхүүжилтэд хамрагдсан байна. 3. Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2021 оны 02 дугаар тогтоолоор өгсөн чиглэлийн дагуу Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай 01/1438, 01/1514 дугаар албан бичгийг Сангийн яаманд хүргүүлж, Засгийн газрын 2021 оны 131 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон. Ноос, арьс ширний бэлтгэлийн үйл ажиллагааг оруулсантай холбогдуулан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний “Хөдөө аж ахуйн зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээний төслийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлсэн.	
33	3.3.11. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно.	1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс олгох татаас, мөнгөн урамшууллын тогтолцоог бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үр дүнтэй холбож боловсронгуй болгоно	2021 - 2024	Үйлдвэрт нийлүүлсэн хүнсний улаанбуудай, ноос, ноолуур, арьс шир, сүү урамшуулал олгоно.	Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор баталсан “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаарлагад нийцсэн малын түүхий сүү бэлтгэн нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу 2020 оны 12 болон 2021 оны 1-3 дугаар сард давхардсан тоогоор 9516 малчин, фермерт 8.5 сая литр сүүг үндэсний 8 үйлдвэрт тушаасны урамшуулалд 4.3 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон.  2. “Мөнгөн урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2020 оны 15 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн болон Сангийн сайдын хамтарсан 290/А-504 дүгээр тушаалаар баталсан “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу	100%	

					<p>2020 онд ХААДС, Улсын нөөцийн газар, дотоодын гурилын үйлдвэрүүдэд стандартын шаардлага хангасан 254,397.04 тонн хүнсний улаанбуудай нийлүүлсэн 13 аймгийн 767 иргэн, хуулийн этгээдэд 22,588,248,700 төгрөгийн урамшуулал олгосон.</p> <p>3. Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоолоор баталсан “Хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу журмын шаардлага хангасан 78 үйлдвэр, цехэд 18,566.3 тонн хонины ноос, 676.2 тонн тэмээний ноос бэлтгэн нийлүүлсэн 88,669 малчин, мал бүхий этгээдэд 30,668,792,500 төгрөгийн мөнгөн урамшууллыг Зохицуулах ажлын хэсгийн дүгнэлт, ХХААХҮ-ийн сайдын А-125 дугаар тушаалын дагуу олгосон. Санхүү, татварын тайлангийн 2020 оны мэдээллээр зөрчилтэй 5 үйлдвэрт ноос бэлтгэн тушаасан малчин, мал бүхий этгээдийн мөнгөн урамшууллыг тус үйлдвэрүүд тайлангаа залруулан, зөрчлөө арилгах хүртэл хугацаанд түр хойшлууллаа. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн стандартын шаардлага хангасан хүнсний улаанбуудайд мөнгөн урамшуулал олгох, тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй бусад аж ахуйн нэгж иргэдэд мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмын төслийг шинэчлэн боловсруулж байна.</p>	
34	3.3.12. Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.	1. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мах, махан бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хадгалалт борлуулалтын цогцолбор төвүүдийг Улаанбаатар	2021 - 2024	Улаанбаатар хотод Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мах, махан бүтээгдэхүүн, хадгалалт борлуулалтын цогцолбор төвийн дэд бүтэц, цахилгааныг шийдвэрлэсэн байна.	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, махны хадгалалт, борлуулалтын 16.0 мянган тонн бүтээгдэхүүн хадгалах багтаамжтай, 90-100.0 мянган тонн барааны эргэлтийн хүчин чадалтай цогцолбор төв байгуулахаар 2018 онд ТЭЗҮ хийж, газрын асуудлыг шийдвэрлэсэн. Тус цогцолбор төвийн цахилгаан, шугам сүлжээний ажлыг 2021 онд санхүүжилтийг шийдвэрлүүлэн эхлүүлэхээр төлөвлөсөн боловч санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна.	30%

		хот, бүсүүдэд байгуулна					
35		2. Мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх, анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч малчин өрхийн үйлдвэрлэл буй түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах тогтолцоог бүрдүүлнэ	2021 - 2024		Мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлын зааврыг Эрүүл мэндийн яамтай хамтран батлуулсан байна.	1. Монгол орны бэлчээрийн мал аж ахуй, малчдын өвөрмөц арга ажиллагааг мал, амьтны тавлаг байдлын зарчим, бэлчээр ашиглах, хамгаалах, сайжруулах “уламжлалт” аргыг мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлог болон орчин цагийн органик үйлдвэрлэлд тавигдах шаардлагын үзэл баримтлалтай уялдуулан “Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлага” стандарт батлуулсан.  2) “Монголын хаан ширхэгт” тохирлын баталгаатай бүтээгдэхүүн хөгжүүлэн, олон улсын хэмжээнд байр сууриа бэхжүүлэх, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд халгүй, чанар аюулгүйн стандартын шаардлага хангасан ээлтэй бүтээгдэхүүн, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих зорилготой ажиллаж байна. Монголын ноос ноолуурын холбоо нь MNS ISO/IEC 17065:2013 стандартын шаардлага хангасан тул Үндэсний итгэмжлэлийн төвөөс тус холбооны дэргэдэх баталгаажуулалтын албанд итгэмжлэлийн гэрчилгээ олгож, 19 нэр төрлийн ноос, ноолууран бүтээгдэхүүнд чанарын баталгаажилт хийсэн. “Монголын хаан ширхэгт” гэрчлэх тэмдгийн brandbook хийх ажлыг АХБ-ны ХАА, хөдөөгийн хөгжлийн техник, туслалцааны төсөлтэй хамтран хэрэгжүүлж реклам, контент хийсэн. “Ханбогд кашимер” ХХК нь “Монголын Хаан Ширхэгт” тохирлын тэмдэгтэй 10 тн хялгасыг ялгасан ноолуурыг 6 дугаар сарын 02-ны өдөр Итали улс руу газраар тээвэрлэсэн. Худалдан авагч тал нь Итали улсын томоохон брэнд Falconeri, Colombo. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн цахим систем нэвтрүүлснээр малчин өрх, үйлдвэрлэгч нарын түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах тогтолцоог бүрдүүлсэн. Малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэх, гэрчилгээ, баталгааны тэмдэг, малчинд мэргэжлийн үнэмлэх олгох, хэрэглэх журмын төслийг ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. Ингэснээр малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэн гэрчилгээ, баталгааны тэмдэг олгох замаар аюулгүй хүнс, малын	70%

					гаралтай түүхий эдийг үйлдвэрлэж, нийлүүлэх, гарал үүслийг баталгаажуулах боломж бүрдэнэ.	
36		3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг Хөдөө аж ахуйн бирж, хоршооны бүтцэд тулгуурлан боловсронгуй болгож, Загвар хоршоодыг байгуулна	2021 - 2024	Хөдөө аж ахуйн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах зорилгоор хөдөө аж ахуйн шинээр бий болсон загвар хоршооны тоо 3	Загвар хоршоодыг байгуулах ажлын хүрээнд: - Орон нутагт буй хоршоодыг чадавхжуулах, түүхий эдийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд олон улсын төсөл хөтөлбөрүүд, Мэргэжлийн холбоод, мах төхөөрөх, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчид болон бусад байгууллагуудтай хамтран сургалтуудыг орон нутагт зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө, гарын авлагаар хангаж байна. Хонины ноосыг машинаар хяргах, бог, бодын арьс ширийг эсгэлтгүйгээр хуулах төхөөрөмж нэвтрүүлэх зэрэг бодит ажлууд хэрэгжиж байна. Баянхонгор аймагт “Мал төхөөрөх, арьс шир эсгэлтгүй хуулах технологи” онол практик хосолсон сургалтыг 2021 онд 5 сард зохион байгуулж мал төхөөрч бэлдэх, мах боловсруулах үйлдвэр цехүүд, инкубатор төв, малчдын хоршоод, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, түүхий эд бэлтгэгчид болон бусад холбогдох байгууллагын нийт 90 гаруй хүнийг хамруулж сертификатжуулсан. Өмнөговь аймагт “Арьс ширэн түүхий эд бэлтгэл” сургалтыг 6 дугаар сард зохион байгуулав. Мөн Хэнтий аймагт ноос хяргах сургалтыг ХААБ-тэй хамтран зохион байгуулаад байна. Загвар хоршоодыг байгуулах ажлын хүрээнд “Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтийн хэлэлцээрийг үндэслэн Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хооронд 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 145/201214/ЗЗББУХТН/497 тоот гэрээ байгуулсан. Төслийн “Хоршоодод үзүүлэх дэмжлэг”-ийн эх үүсвэрт хуваарилагдсан 810 сая төгрөгийг Архангай, Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн хөдөө аж ахуйн хоршоодод Жижиг, дунд үйлдвэрийн газраар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгохоор болсон. Хөнгөлөлттэй зээл нь сум, орон нутагт загвар болохуйц хоршоо болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход анхаарч ажиллаж байна. Жижиг, дунд үйлдвэрийн газарт одоогийн байдлаар хөнгөлөлттэй зээл авахаар төсөл хэрэгжиж буй аймгуудын хоршоодоос	50%

					шалгарсан 9 хоршооны 620,0 сая төгрөгийн төслийн зээлийн гэрээ хийгдэж байна.	
37	3.3.13. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ.	1. Экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд даатгалын үйлчилгээг нэвтрүүлнэ	2021 - 2024	Судалгаа, бэлтгэл ажил	ХХААХҮ-ийн Сайдын 2021 оны А-78 дугаар тушаалаар Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах ажлын хэсэг байгуулагдаж, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу үзэл баримтлалын төсөл, холбогдох судалгаа хийж байна. Хуулийн төсөл /2023/ батлагдсанаар Экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд даатгалын үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ. Уул уурхайн бус салбарын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилгоор "Экспортыг дэмжих төсөл"-ийн хүрээнд Үндэсний Давхар Даатгал ХК-тай хамтран Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхээр 2021 оны 03 дугаар сараас даатгалын бүтээгдэхүүний судалгааны ажлыг эхлүүлсэн. Зөвлөхөөр Герман улсын Оффенбург их сургуулийн Худалдаа ба инновацийн институтын захирал профессор Андреас Класен ажиллаж байна. Даатгуулагчид үүсэх эрсдэлээс хамгаалж олон улсын давхар даатгалын 12 компанид хамтран ажиллах хүсэлт хүргүүлж, хүсэлтийг хүлээн авсан. Олон улсын давхар даатгагч SCOR групптэй гэрээ байгуулахаар хамтран ажиллах нөхцөлийг тохиролцож байна. Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүний судалгааны ажлын баримт бичигт Олон улсын давхар даатгагчийн саналыг тусган 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр олон нийтэд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.	50%
38		2. Жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн	2021 - 2024	Бичил, жижиг, дунд үйлдвэрийг хөнгөлөлттэй зээл, санхүүжилтээр дэмжих замаар ажлын байр шинээр бий болгосон байна /шинээр бий болсон ажлын байр 2000/	Монгол Улсын Засгийн газраас "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөө"-г баталсан. Энэ арга хэмжээний хүрээнд ажлын байрыг дэмжих хоёр их наяд төгрөгийн зээлийг арилжааны банкаар дамжуулан жилийн гурван хувийн хүүтэй, гурван жилийн хугацаатай, эхний 12 сар хүртэл үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэйгээр 500 хүртэл сая төгрөгийн зээлийг олгохоор боллоо. Тус зээлд хамрагдах жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн барьцаа хөрөнгө хүрэлцээгүй тохиолдолд Зээлийн батлан даалтын сангаар 60	70%

		бодлого хэрэгжүүлнэ			хүртэлх хувийг батлан даалгах боломжтой бөгөөд батлан даах дээд хэмжээ 300,0 сая төгрөг байхаар Засгийн газар, Монголбанк, арилжааны банкуудтай гэрээ байгуулсан. 2021 оны 05 дугаар сарын байдлаар 1 их наяд 90 сая төгрөгийн зээлийг 14,948 иргэн аж ахуйн нэгжид олгосон бөгөөд 53364 ажлын байр хадгалж, 2748 шинэ ажлын байр бий болгож, үүнээс 4,1 тэрбум төгрөгийн 12 зээлд 1,9 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалт гаргасан байна. Хэнтий аймагт ажлын байрыг дэмжих зээлийн хүрээнд 36 аж ахуйн нэгж, 160 иргэнд 10,5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож 259 ажлын байрыг хадгалж үлдсэн байна. Мөн Баян-Адарга, Дадал сумдын сум хөгжүүлэх сангаас 17 иргэн аж ахуйн нэгжид 153 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож 63 ажлын байрыг бий болгон ажиллалаа.	
39		3. Орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурлан "Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн" аяныг зохион байгуулах тогтолцоог сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ	2021 - 2024	Аяныг зохион байгуулна	"Нэг суурин - Нэг бүтээгдэхүүн" аяны хүрээнд 21 аймгаас орон нутгийн брэнд бүтээгдэхүүний судалгаа авч, тэдгээрт үндэслэн "Орон нутгийн-Онцлох бүтээгдэхүүн" нэрээр аймгуудын брэнд бүтээгдэхүүний танилцуулгыг цувралаар бэлтгэн олон нийтэд сурталчилж байна. Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймгийн 67 брэнд бүтээгдэхүүнийг олон нийтийн сүлжээгээр түгээж цахим орчинд нийт 37,955 хүнд хүргэж ажилласан байна. Цаашид үлдсэн аймгуудын танилцуулгыг бэлтгэн 7 хоногт 3 аймгийн бүтээгдэхүүнийг цахим орчинд сурталчилж ажиллаж байна.	100%
40	3.3.14. Оюутолгой, Эрдэнэт зэрэг томоохон үйлдвэрийн захиалгат ажлыг үндэсний жижиг, дунд бизнес эрхлэгчид	1. Үндэсний бүтээн байгуулалтын томоохон төсөл хөтөлбөр, төрийн байгууллага,	2021 - 2024	150 ЖДҮ эрхлэгчийг холбосон байна	Дотоодын үйлдвэр эрхлэгчдийг төрийн худалдан авалтаар дэмжих, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудтай холбох, бараа бүтээгдэхүүнийг танилцуулах зорилгоор "Эх оронч худалдан авалт- Үндэсний үйлдвэрлэл 2021" уламжлалт үзэсгэлэнг анх удаа цахим хэлбэрээр 2021.04.01-05.01-ний өдрүүдэд зохион байгуулсан ба нийт 293 үйлдвэр эрхлэгч, 93 төрийн байгууллага үзэсгэлэнд оролцож, үзэсгэлэнгийн	90%

	гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлнэ.	томоохон аж ахуйн нэгжүүдэд чанар стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх тогтолцоог хөгжүүлэх, хэрэглэгч, үйлдвэрлэгчийг холбоно				танхимаар нийт 26000 гаруй хүн, хурлын танхимаар 2000 гаруй хүн, цахим хуудсаар 46200 гаруй хүн зочилж мэдээлэл авсан байна. Уг арга хэмжээний хүрээнд Эрдэнэт, Оюу толгой компаниудын төлөөллүүд дотоодын үйлдвэрүүдээс худалдан авах боломжтой бараа бүтээгдэхүүний мэдээллээ танилцуулж оролцов. Оюу толгой компанийн ханган нийлүүлэлтэд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг кластераар нэгтгэн оролцуулахаар тохиролцов. Дотоод болон гадаад худалдаанд баримтлах хууль, журам, тулгамдсан асуудлын талаар сургалт, мэдээллийг цахим хэлбэрээр зохион байгуулав. <a href="https://mofa.gov.mn/exp/article/entry/2353">https://mofa.gov.mn/exp/article/entry/2353</a> , <a href="https://smefund.gov.mn/news/9/single/470">https://smefund.gov.mn/news/9/single/470</a> , Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр 2020 онд дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүний тайлан"-г Засгийн газрын 2021 оны 30 дугаар тэмдэглэл гарсан.	
41	3.3.15. Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.	2. Байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийг санхүүжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна	2021 - 2024	4 төслийг санхүүжүүлнэ	Байгаль, орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай 16 төслийн мэдээллийг нэгтгэж, ЖАЙКА ОУБ-ын санхүүжилттэй ЖДҮ-ийг дэмжих, байгаль орчныг хамгаалах төслийн нэгжид хүргүүлсэн. Үүнээс 3 төслийг арилжааны банкаар дэмжсэн бөгөөд, ТУХ-ны хурлаар хэлэлцүүлж батлуулав.	90%	
42	3.7.11. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж,	7. Дархан хотын арьс ширний үйлдвэрлэл технологийн паркийн цэвэрлэх байгууламж	2020 - 2023	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 30%.	Дархан хотын арьс ширний үйлдвэрлэл технологийн паркийн цэвэрлэх байгууламж шинээр барих ажилд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд: 1) "Дарханы арьс ширний цогцолбор" төслийн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн дэд бүтцийн ажилд аудит хийлгэж, дүгнэлт гаргах хүсэлтийг 01/941 албан тоотоор Үндэсний аудитын газар, УИХ-ын Төсвийн байнгын хороонд "Аудитын сэдэв батлах	30%	



	ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ.	шинээр барих ажилд дэмжлэг үзүүлнэ.				<p>тухай” 05 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг 01/1293 тоот албан бичгээр УИХ-ын Төсвийн байнгын хороонд тус тус хүргүүлээд байна.</p> <p>2) 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг тус тус үндэслэн "Нэмэгдсэн өртгийн албан татвар болон Гаалийн албан татвараас 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд чөлөөлөгдөх Дархан-уул аймагт барих дархан арьс ширний цогцолборын арьс, шир боловсруулах үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламж дэд бүтцийн үндсэн хөрөнгөнд бүртгэгдэх импортоор оруулах тоног төхөөрөмжийн жагсаалт"-ыг батлуулахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулаад байна.</p>	
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
43	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг	2021 - 2024	үйл ажиллагааны зардлаар	Дүрэмд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаарх сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг эхлүүлнэ.	<p>ХХААХҮЯ-ны Хөдөлмөрийн дотоод журамд Төрийн албан хаагчийн ёс зүй гэсэн бүлэг тусгаж өгсөн ба энэ журам болон Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг албан хаагчид үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Албан хаагчдын санал асуулгыг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А-301 дүгээр тушаалаар Ёс зүйн зөвлөл шинэчлэн байгуулсан бөгөөд 2021 онд 2 өргөдөл ирснийг хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Хөтөлбөр батлах тухай” 2018 оны А-380 дугаар тушаалаар Сургалт, Нийгмийн баталгааны хөтөлбөрийн батлуулсан. Энэ хөтөлбөрийн дагуу жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2021 оны хагас жилийн байдлаар: 1. АТГ-аас зохион байгуулсан авлига ашиг сонирхлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь сэдэвт 2 цагийн сургалтад нийт албан хаагчдыг цахим хэлбэрээр хамруулсан. 2. Мөн ТАЗ-өөс зохион байгуулсан дараах сургалтуудад цахимаар холбогдох албан хаагчдыг хамрууллаа. - “Өөрчлөлтөд дасан зохицох нь” - “Төрийн албанд: Шинэтгэлд</p>	90%

		хангаж ажиллана.				шимтэхийн учир” - Ажлын байранд эрүүл мэндээ хамгаалах нь” - Төрийн удирдлагын инновацид дизайн сэтгэлгээ, аргачлал ашиглах нь” - Төрийн албан хаагчийн Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах гарын авлагын танилцуулгын талаар - "Монгол Улсын Төрийн албан дахь жендерийн тэгш байдлыг хангах хүрээ" - Төрийн албаны үйлчилгээний чанар хүртээмж, үр нөлөө - Монгол төрийн түшмэдийн уламжлал, ёс суртахууны асуудал - Төрийн байгууллага дахь ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахад удирдлага ба нийгмийн албан тушаалтны үүрэг - Төрийн байгууллагад зан үйлийн менежментийг хэрэгжүүлэх нь 3. Мөн Цогц чадамжид суурилсан төрийн алба сэдэвт 2 өдрийн вакумжсан цахим сургалтуудад албан хаагчдыг чиг үүрэгт хамаарах байдлаар сонгон хамруулсан байна.	
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
44	5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.	2. Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана.	2020 - 2024		Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулна.	"Хариуцлагатай нүүдэлчин" стандарт боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 03 сарын 11-ний өдрийн А-68 дугаар тушаалаар байгуулж, уг стандартыг СХЗГ-ын Стандартчиллын техникийн хороогоор батлуулав. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд мал аж ахуйн салбарт хамаарах 4 заалт бүхий саналыг ХХААХҮ-ийн үйлдвэрийн сайдын 01/1779 тоот албан бичгээр БОАЖЯ-нд хүргүүлсэн. 2020 оны жилийн эцсийн мал тооллогоор өмнөх оноос малын тоо 3.9 сая /5.5%/ толгойгоор буурлаа. 2020-2021 онд нийт 24.8 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар 21943.48 мянган тонн CO <sup>2</sup> экв хүлэмжийн хийг буурууллаа. Зорилтот түвшинтэй харьцуулахад 307.78 мянган тонн CO <sup>2</sup> экв-р их байлаа. Тариалангийн талбайн хөрсний үржил шим, нар салхины элэгдэл эвдэрлээс хамгаалахаар тариалангийн талбайн 2.5 км ойн зурвасыг Төв аймгийн Борнуур суманд Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд байгуулсан. Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар үйлдвэрлэл, технологийн паркийн төслийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж, эхний үйлдвэрүүдийг байгуулаад байна. Шингэн хог хаягдал боловсруулж цахилгаан эрчим хүчний	90%

					<p>үйлдвэр байгуулахаар Засгийн газраас концессийн гэрээ байгуулсан. Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар БХЯ-ны Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэд Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хэрэгжилтэд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг бүтээн байгуулалтад оролцуулах төслийн баг байгуулсан. Ойн цэвэрлэгээний ажилд шаардагдах мэргэжилтэй боловсон хүчин, бригад, техник тоног төхөөрөмжийн судалгааг БХЯ-ны Жанжин штабтай хамтран боловсруулж, хөрөнгө оруулалтыг Беларусь, БНХАУ-ын буцалтгүй тусламжаас шийдвэрлүүлэх төслийг БХЯ-нд танилцуулсан. Байгаль, орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай 16 төслийн мэдээллийг ЖАЙКА ОУБ-ын санхүүжилттэй ЖДҮ-ийг дэмжих, байгаль орчныг хамгаалах төслийн нэгжид хүргүүлснээс 3 төсөл арилжааны банкаар дэмжигдсэн, төслийн удирдах хорооны хурал Ковидын улмаас хойшлогдоод байна.</p>	
--	--	--	--	--	---	--